“Юү Жи Эл Интерпрайзис”
ХХК

“УЛААН-ОВОО НҮҮРСНИЙ УУРХАЙГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

ОРШИЛ 1
НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 2
1.1. “Юү Жи Эл Интерпразис” ХХК-ийн үйл ажиллагаа 2
1.2. Төслийн байршил 2
1.3. Хүчин чадал, ажиллах горим 3
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ 5
2.1. Газрын гадарга, байр зүй 5
2.2. Цаг уур, уур амьсгал 5
2.4. Геологийн тогтоц ба геоморфологи 5
2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал 6
2.6. Ургамлын нөмрөг 6
2.7. Амьтны аймаг 6
2.8. Гадаргын ус 7
2.9. Тусгай хамгаалалтай газар нутаг 7
2.10. Нийгэм-эдийн засаг 7
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ 8
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 8
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 9
3.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн 9
3.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах 9
3.5. Нүүлгэн шилжүүлэлт 9
3.6. Түүх, соёлын өвийг хамгаалах 9
3.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 10
3.8. Хог хаягдлын төлөвлөгөө 10
3.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 10
3.10. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ 10
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 11
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 12
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 15
4.3. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн 15
4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 15
4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ 16
4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 16
4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 17
4.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 18
4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 19
4.10. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө 21
4.11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах 22

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол 3
Хүснэгт 2. Уурхайн ажлын горим 4
Хүснэгт 3. Уурхай дээр ажиллах нийт ажилчдын тоо 5
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 12
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө 15
Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 16
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 17
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө 18
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 19
Хүснэгт 10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө 22
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн 23

ОРШИЛ

“Юу Жи Эл Интерпрайзис” ХХК-ийн “Улаан-Овоо нүүрсний уурхайг ил аргаар ашиглах”-ийн /цаашид “Төсөл” гэх/ зориулалттай төслийн газар нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрладаг.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

“Юу Жи Эл Интерпрайзис” ХХК нь төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах хөрөнгө оруулалт болон бүтээгдэхүүн нийлүүлэх худалдан авагчийн сонгон шалгаруулалтын ажил удааширсантай холбоотойгоор 2026 оны 4-р улиралд үйл ажиллагаа явуулахаар энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулаад байна.
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.
Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь зөвхөн төслийн ашиглалтын үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн бөгөөд холбогдох бусад бүхий л ажиллагааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Улаан-Овоо нүүрсний уурхайг ил аргаар ашиглах”
Төсөл хэрэгжүүлэгч:	“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, Гандан, Амарсанаагийн гудамж, 12-1, Хатансүлжээ ХХК-ийн байрны Б корпус 101 тоот
Төслийн байршил, хаяг:	“Улаан-Овоогийн нүүрсний орд” нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км, Сүхбаатар хотоос 107 км, Шаамарын төмөр замын өртөөнөөс 120 км зайд Зэлтэрийн голын хөндийд байрлана.
Газар ашиглах зориулалт:	Улаан-Овоогийн нүүрний ордыг ил аргаар олборлон ойролцоо төв суурин гарын хэрэглэгчид, дулааны цахилгаан станцуудад нийлүүлэхийн зэрэгцээ ОХУ, Хятанд, Өмнөд Солонгос зэрэг орнуудад экспортлох.
Төслийн хүчин чадал:	“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Улаан-Овоогийн нүүрсний ордыг ашиглах ТЭЗҮ-д тус ордноос жилд 500-1000 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтай байхаар төлөвлөн боловсруулсан байна.
Улсын бүртгэлийн дугаар:	9019001016
Регистрийн дугаар:	5002265
Дэд бүтэц:	***Цахилгаан:*** Түшиг сумаас цахилгаан эрчим хүчний системээ хангана. ***Замхарилцаа:*** Улаанбаатар-Сүхбаатарын төмөр зам, хатуу хучилттай авто замаас 110 км зайд байрлана. ***Худаг, ус:*** Гүний худгаас төслийн унд ахуйн усны хэрэглээг хангана.

1.1. “Юү Жи Эл Интерпразис” ХХК-ийн үйл ажиллагаа

Төслийн зорилго

Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар олборлон ойролцоо төв суурин газрын хэрэглэгчид, дулааны цахилгаан станцуудад нийлүүлэхийн зэрэгцээ ОХУ, Хятад, Өмнөд Солонгос зэрэг орнуудад экспортлох зорилготой

1.2. Төслийн байршил

“Улаан-Овоогийн нүүрсний орд” нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км, Сүхбаатар хотоос шулуунаар 107км, Шаамарын төмөр замын өртөөнөөс 120 км зайд Зэлтэрийн голын хөндийд байрлана.

Хүснэгт 1. *Төслийн тусгай зөвшөөрлийн солбицол*

№	Газарзүйн солбицол		Тэгш өнцгийн солбицол	
	Уртраг	Өргөрөг	X	Y
1	104⁰58ᴵ38.050ᴵᴵE	50⁰19ᴵ26.950ᴵᴵN	498379.5741	5574672.75
2	104⁰58ᴵ38.040ᴵᴵE	50⁰19ᴵ48.950ᴵᴵN	498379.0174	5573499.07
3	104⁰58ᴵ26.160ᴵᴵE	50⁰19ᴵ48.950ᴵᴵN	498144.058	5573499.148
4	104⁰58ᴵ17.590ᴵᴵE	50⁰19ᴵ48.950ᴵᴵN	497974.5629	5573499.21
5	104⁰58ᴵ10.950ᴵᴵE	50⁰19ᴵ51.940ᴵᴵN	497843.2652	5573564.123
6	104⁰58ᴵ4.100ᴵᴵE	50⁰19ᴵ53.650ᴵᴵN	497707.8013	5573591.668
7	104⁰58ᴵ0.460ᴵᴵE	50⁰18ᴵ53.650ᴵᴵN	497635.8351	5573644.515
8	104⁰57ᴵ56.610ᴵᴵE	50⁰19ᴵ56.390ᴵᴵN	497559.732	5573729.178
9	104⁰57ᴵ51.470ᴵᴵE	50⁰19ᴵ58.310ᴵᴵN	497458.1073	5573788.528
10	104⁰57ᴵ37.230ᴵᴵE	50⁰19⁰0.980ᴵᴵN	497176.5318	5573871.137
11	104⁰57ᴵ22.890ᴵᴵE	50⁰19ᴵ2.000ᴵᴵN	496892.9575	5573902.799
12	104⁰57ᴵ14.970ᴵᴵE	50⁰19ᴵ0.560ᴵᴵN	496736.3024	5573858.417
13	104⁰57ᴵ6.050ᴵᴵE	50⁰18ᴵ56.170ᴵᴵN	496559.8091	5573722.938
14	104⁰57ᴵ6.050ᴵᴵE	50⁰19ᴵ26.960ᴵᴵN	496560.4263	5574673.928
15	104⁰57ᴵ28.480ᴵᴵE	50⁰19ᴵ26.960ᴵᴵN	497003.9424	5574673.658


1.3. Хүчин чадал, ажиллах горим

“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь 2026 онд нийт олборлох нүүрсний хэмжээ 500.0 мян.тн , хөрс хуулалт 612.0 мян.м^3, хөрс хуулалтын дундаж коэффициент 1.19 м^3/тн байна.

“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Улаан-Овоо нүүрсний ордыг ашиглах төслийн ТЭЗҮ-д ордоос жилд 500-1000 тн нүүрс олборлох хүчин чадалтай байхаар төлөвлөн боловсруулсан байна. Нүүрсний олборлолтыг ил аргаар явуулах бөгөөд хөрс хуулалт, тээвэрлэлт, олборлолтод ашиглах үндсэн техник нь экскаватор, бульдозер, автосамосвол, өрмийн машин зэрэг байна.



Зураг 1. Уурхайн ашиглалтын байдал



Зураг 2. Төслийн байршил

Уурхайн ажлын горим

Хүснэгт 2. *Уурхайн ажлын горим*

Ангилал	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
	Календарь хоног	Хоног	365
	Баяр ёслолын хоног	Хоног	0
	Төлөвлөгдсөн хоног	Хоног	360
Төлөвлөгөөт хугацаа	Ээлжийн хугацаа	Цаг/ээлж	12
	Хоногт ажиллах ээлж	Ээлж/хоног	2
	Хоногт ажиллах цаг	Цаг/хоног	24
	Төлөвлөгдсөн цаг	Цаг/жил	8,448
Техник үйлчилгээ, засвар	Төлөвлөгөөт үйлчилгээ, засвар	Цаг/жил	420
	Төлөвлөгдөөгүй засвар	Цаг/жил	420
	Засвар, үйлчилгээ хийх нийт хугацаа	Цаг/жил	840
	Техникийн бэлэн байдал	%	90%
	Техникийн бэлэн байдлыг тооцсон цаг	Цаг/жил	7,608
	Жилд ажиллах ээлжийн тоо	Ээлж/жил	634
Сул зогсолт	Цаг агаар, байгалийн хүчин зүйл (5хон/жил)	Цаг/жил	120
	Хоолонд орох хугацаа (60мин/ээлж)	Цаг/жил	634
	Ээлж солих (20мин/ээлж)	Цаг/жил	211.3
	Үзлэгийн хугацаа (5мин/ээлж)	Цаг/жил	52.8
	Зогсолт хийх хугацаа	Цаг/жил	1,018
	Ашиглалтын бэлэн байдал	%	87%
	Үйл ажиллагааны цаг	Цаг/жил	6,590
Саатал	Түлш цэнэглэх хугацаа (15мин/ээлж)	Цаг/жил	158.5
	Жилийн цаг ашиглалт	%	86%
	Бүтээлийн ажиллах цаг	Цаг/жил	6,972.0

Хүснэгт 3. *Уурхай дээр ажиллах нийт ажилчдын тоо*

Хэсгүүд	Ажилчдын тоо
Захиргаа удирдлагын хэсэг	13
Инженер техникийн алба	24
Уул технологийн хэсэг	70-86
Бусад хэсэг	66
Дүн	**173-189**

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Газрын гадарга, байр зүй

Улаан-Овоогийн нүүрсний орд нь Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төвөөс баруун тийш 7 км зайд орших бөгөөд Зэлтэр голын хөндий нь хойд болон өмнөд талаасаа Жид, Бүтээлийн нурууны салбар уулсаар хүрээлэгдсэн бөгөөд уул нь 40-60км-ийн өргөнтэйгөөр 100км орчим урт үргэлжилнэ.Уул нуруу нь зүүн хойд чиглэлд сунаж тогтсон бөгөөд Зэлтэр гол болон Сэлэнгэ мөрний голын системийн усны хагалбар юм. Ордын орчмын уулс нь Зэлтэрийн голд цутгадаг жижиг горхинуудын гольдиролуудаар хөндлөн хэрчигдсэн бөгөөд хэд хэдэн жижиг горхи ордын талбайг дайран Зэлтэрийн голд цутгадаг. Улаан-Овоогийн нүүрсний орд нь Рихтерийн шаталбараар 8 хүртэл баллын газар хөдлөлийн бүсэд оршиж байна. Сэлэнгэ аймгийн Түшиг сум нь физик газар зүйн хувьд Хангайн нурууны салбар бүтээлийн нурууны салбар бүхий ойт хээрийн бүсэд багтдаг. Сумын нутаг дэвсгэр нь ой модоор хүрээлэгдсэн мал аж ахуйн болон газар тариалан голлон эрхэлдэг. Нийт 249282 га нутаг дэвсгэртэй.

2.2. Цаг уур, уур амьсгал

Төслийн талбай нь газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны хэмжээ жилд 100-150мм хүрэх ба үүний 60-70% нь зуны 6-8 дугаар саруудад ордог. Жилийн хамгийн өндөр агаарын температур нь 6-7 дугаар саруудад 35-40^{0}C хүрдэг бол өвлийн хамгийн бага температур нь 12-1 дүгээр саруудад -35-40^{0}C хүрнэ. Цасны дундаж зузаан нь 10-20 см, хунгарласан хэсэгтээ хамгийн ихдээ 2м хүрнэ. Салхи нь ихэвчлэн баруун хойд болон зүүн хойд чиглэлээс дунджаар 7м/сек хурдтай салхилна.

- Жилийн дундаж салхины хурд 2-5м/с
- 1 дүгээр сарын дундаж температур -28.5^{0}C
- 7 дугаар сарын дундаж температур 19.20^{0}C
- Жилийн хур тунадасны нийлбэр 235 мм

2.4. Геологийн тогтоц ба геоморфологи

Улаан-Овоогийн чулуун нүүрсний орд дунд-дээд юрагийн настай Зэлтэрийн хотгорт оршино. Зэлтэрийн хотгорт оршино. Зэлтэрийн хотгор нь 80-аад км сунаж тогтсон, хэд хээн жижиг хотгоруудаас бүрэлдэн тогтдог уулс хоорондох томоохон геологийн структур юм. Тухайлбал, Гурмансангийн, Хундаа голын, Улаан-Овоогийн, Түшигийн, Хуширийн гэсэн хотгоруудаас бүрэлдэн тогтох бөгөөд тэдгээр нь хоорондоо доод палеозойн хувирмал занар болон дээд пермийн галт уулын /вулканоген/ чулуулгуудын өгөгдлөөр зааглагдана.

Районы геологийн тогтцод дунд кембрийн доод ордовикийн ангилагдаагүй ногоовтор өнгийн хувирмал занар ба занаржсан нормаль-тунамал чулуулаг, доод пермийн галт уулын хурдас

болон дунд-дээд юрагийн настай нүүрс агуулагч терриген хурдасууд оролцох байна. Тухайн районд дараах төрлийн давхарга зүйг ялгаж болно. Үүнд:

- Доод палеозойн хурдас /P_{21}/
- Доод перм /P_1 hn/
- Юрагийн тогтолцоо /J_{2-3} chg/
- Дөрөвдөгчийн тогтолцоо /$Q_{III-IV;}$ Q_{IV}/

2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт, Зэлтэрийн голын хөндийд байрлах “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК-ийн Улаан-Овоогийн нүүрсний уурхайн төслийн талбай нь Зэлтэрийн голын хөндийд оршино. Газрын гадаргын хэлбэр дүрсийн хувьд уулын өвөр хажуу болон голын хөндий, нугын систем бүрэлдэн тогтсон байна. Судалгаанд хамрагдсан 619.94 га талбайд уулын ойн ширэгт бараан, аллювийн нугын хөрс зонхилон тархсан байна. Уурхайн талбайн хөрсөн бүрхэвч хүний үйл ажиллагаа болон тээвэрлэлтийн явцаас шалтгаалан элэгдэлд өртсөн байна.

2.6. Ургамлын нөмрөг

Судалгаа гүйцэтгэсэн талбай нь уулын ойт хээрийн дэд бүслүүрт хамаарах 2 бүлгэмдлээс бүрдэнэ. Ургамалжилтын зүйлийн хувьд 17 овгийн 37 төрлийн нийт 44 зүйлийн ургамал бүртгэгдсэн. Эдгээр ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг-2, сөөгөнцөрлөг-1, олон наст өвслөг ургамал-38, хоёр наст-1, нэг наст-1 зүйл тус тус тэмдэглэгдэв.

Судалгааны талбайн эргэн тойронд ургамлан нөмрөг хүний үйл ажиллагааны улмаас ага зэрэг нөлөөлөлд өртсөн боловч ургамал бүлгэмдэл хэвийн төлөв байдалтай. Ургамлын арвийн үнэлгээний хувьд дэд зонхилогч ургамлууд нь cop1, sp, дагалдагч зүйл ургамлууд нь sp, sol арвийн үнэлгээтэй, тусгаг бүрхцийн ихэнх хувийг олон наст өвслөг ургамлууд бүрдүүлж, тэдгээрийн 2-р ташингыг олон наст ургамал бүрдүүлж байна. Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл мод дээд дэд, сөөг, сөөгөнцөрлөг ургамал дунд, дээд олон наст ургамлууд доод дэд ташингыг бүрдүүлж байна.

2.7. Амьтны аймаг

Амьтны аймгийн ховор, ховордсон зүйлийг хамгаалах чиглэлийн үүднээс авч үзвэл энэ нутаг шувуу, хөхтнөөр олон улс, Монголын анхаарал татсан устаж байгаа юмуу онцгой ховор зүйл цөөнтэй. Манай орны бусад зарим бүс нутагтай харьцуулахад шувуу хөхтөн нь одоохондоо онц их хөндөгдөөгүй нутаг гэж үздэг.

Монгол оронд 30 орчим зүйл хоёр нутагтан, мөлхөгчид байдаг. Хоёр нутагтнаас сибирийн мэлхий, монгол бах хоёр хамгийн их тархацтай. Тус аймагт хоёр нутагтан мөлхөгчдийн оршин тархсан нягтшил бага. Харин шавжийн аймаг зүйл бүрдлээр баян. Эх газрын гандуу уур амьсгалын нөлөөгөөр хуурайсаг болон нуугдамхай хэлбэрийн шавж, ялангуяа авгалдайн шатандаа далд газар амьдралтай ихээхэн байна. Уулын болон ойт хээрийн бүсэд шавжийн аймаг унаган зүйл олонтойгоор онцлог болно.

2.8. Гадаргын ус

Улаан-Овоогийн нүүрсний ордын район нь гадаргын усны сүлжээгээр элбэг бөгөөд ордын нүүрсний үе давхарга нь Зэлтэрийн голын хөндий болон голын хойд талд байрлалтай байна. Зэлтэр голын усны горим, нөөц харьцангуй бага судлагдсан байна. Хаврын шар усны болон дулааны улирлын хур борооны үерийн горимтой голд хамрагдана. 2004 оноос эхлэн усны горимын байнгын ажиглалтыг хийж байна. Голын сав газар ойгоор бүрхэгдсэн тул голын урсац харьцангуй тогтвортой, урсцын модуль 2-4л/с ам км, усны өнгөрөлт 2005 оны байдлаар 12.1 гоо м/с жилийн дундаж урсацтай байна. Жилийн урсцын 46 орчим хувь нь дулааны улирлын 6-8 дугаар ногдоно.

2.9. Тусгай хамгаалалтай газар нутаг

Улаан-Овоогийн орд нь тусгай хамгаалалтай газар нутагт хамаарагдахгүй. “Юү Жи Эл Интерпрайзис” ХХК нь Монгол улсын Хилийн тухай хуулийн 27-р зүйл заасан Улсын хилийн зурвас мөрдөх журам, хориглох зүйлийг нарийн чанд баримтлан, хил хамгаалах байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлж ажиллавал зохино.

2.10. Нийгэм-эдийн засаг

Сумын хэмжээнд нийт 13918 га эргэлийн талбайтай. Үүнээс 27 га талбайд хүнсний ногоо, 6265 га талбайд улаан буудай, 1682 га талбайд бусад таримал тариалж байна. Сумын хэмжээгээр жилд 6265 га талбайд үр тариа, 81,6 га талбайд төмс, 27 га талбайд хүнсний ногоо, 1653 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 16267 тн үр тариа, 1715 тн төмс, хүнсний ногоо, 3535 тн тэжээлийн ургамал хураан авсан.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Төлийн үйл ажиллагаанаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын явцад хийсэн судалгаа, шинжилгээ, судлаачдын гаргасан үнэлгээ, дүгнэлтүүдийг үндэслэн төслийг хэрэгжүүлэхдээ орчиндоо үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах, арилгахад дараах зөвлөмж, арга хэмжээ, стандартын шаардлагыг мөрдлөг болгон ажиллах, цаг тухайд нь авч хэрэгжүүлэх.

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө Агаар

Агаарын чанарын гадаад орчны түгээмэл тархацтай бохирдуулах бодисыг хянахдаа “Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандартаар, ”Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008 стандарт”-аар, Ажлын байрны орчны бичил цаг уурын эрүүл ахуйн шаардлага, агаар дахь хорт бодисыг хянахдаа “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй, Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023 стандартаар тодорхойлж төсөл хэрэгжүүлэгч эдгээрээс давах бохирдуулагч гаргахгүй байхад үндэслэгдэнэ.

- Агаарын тоосжилт бууруулах зорилгоор технологийн замыг тогтмол услах;
- Алсын замд нүүрс тээвэрлэх үедээ авто самосвалуудын тэвшийг бүтээж байх шаардлага тавьж ажиллах;
- Агаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Хорт хий, дуу чимээ гарч болзошгүй ажлын байранд /тэсэлгээ/ ажиллагсдыг хошуувч, баг, чихний бөглөө зэрэг шаардлагатай хамгаалах хэрэгслээр хангах

Гадаргын ба газрын доорх усны нөөц

Төсөл хэрэгжүүлэгч нь усны нөөц, чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх , багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Үүнд:

- Шүүрлийн усан сангийн усанд усны чанарын шинжилгээг улирал тутам тогтмол хийж голын усны чанарын боломжит хэмжээгээр дөхүүлэн нийцүүлэх
- Гүний худгууд болон ундны усны чанарыг тогтмол давтамжтайгаар хянах

Хөрсөн бүрхэвч

Төслийн хэрэгжилтийн улмаас тухайн орын хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр доор арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Шимт хөрсийг стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах, эргүүлэн нөхөн сэргээлтэд ашиглах, нэг наст юм уу олон наст үр тарих
- Шатахуун асгаралт үүсэж хөрсөнд нэвчихээс сэргийлж байнгын хяналт тавьж байх
- Машин, механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр, талбайд хийж гүйцэтгэх; Ажилласан тос, тослох материалын хаягдлыг тос, тослох материалын хаягдал цуглуулах цэгт цуглуулах;
- Хөрсний чанар, бохирдлыг давтамжтайгаар хянах;

- Тээврийн хэрэгслийн маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулах

Ургамлан нөмрөг

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд: Уурхай орчмын талбайд ургамлан аймаг, ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжлийн судалгаа, хяналт хийх

3.2. Орон нутагтай байгуулсан гэрээний дагуу ойжуулалтын ажил

20 га талбайд ойжуулалт хийх. Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулж түүний дагуу хэрэгжүүлж орон нутагт хүлээлгэн өгөх.

3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооно. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооно. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ. Эдгээр таван хүчин зүйлийн дөрвөн нь орон зайн хүчин зүйл бөгөөд тав дахь нь цаг хугацааны хүчин зүйл юм.
Үүнд:

- Амьдрах орчны төрөл
- Экосистемийн ховор байдал
- Экологийн эрүүл байдал
- Ландшафтын байршил
- Нөлөөллийн хугацаа

Орон нутгийн хариуцагчгүй хуучин хогийн цэгийн нийт 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх.

3.4. Нүүлгэн шилжүүлэлт

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд айл өрхийг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах

Хайгуулын ажлын явцад, уурхайн лицензийн талбайгаас нийт 13 дурсгал ирүүлсэн бүртгэл тэмдэглэж авсны 6 нь зэвсгийн үед (МЭӨ XII-IV зуун), 2 нь дундад зууны үед (МЭ X-XIV зуун) холбогдох булш байгаа бол он цаг тодорхойлох боломжгүй (хэлбэр нь тодорхойгүй) булш 5 байна. Энэхүү хайгуулаар олдсон дурсгалууд бөгөөд эдгээрийг түүх, соёлын өвийг эрэн сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10, 17.12 болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндсэн түүх археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтад авч анхааран, зайлшгүй тохиолдолд, чөлөөлөх арга хэмжээ авна.

- Мэргэжлийн байгууллагаар малтлага судалгаа хийлгэх
- Илэрсэн дурсгалыг авран хамгаалах

3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

- Үерийн хамгаалалтын суваг, шуудуунд байнга хяналт тавьж засаж янзалж байх
- Гал унтраах хэрэгслээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх

3.7. Хог хаягдлын төлөвлөгөө

- Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах
- Ахуйн хог хаягдлын ангилан ялгалтыг тогтмол хийх
- Хог хаягдлын түр цэг байгуулах
- Орчны хогонд хяналт тавьж, цэвэрлэгээг тогтмол хийх
- Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох
- Тээврийн хэрэгслийн аккумлятор ашигласан тос зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг холбогдох журмын дагуу цуглуулж, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж компанитай гэрээ байгуулан хүлээлгэн өгөх
- Ажиллагсад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах

3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг (агаар, хөрс, усан орчин)-д сөрөг нөлөөлөл, өөрчлөлтийг үзүүлж байгаа эсэхэд хяналт тавих, бохирдлыг хянах боломж бүрдэнэ.

3.9. Байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

- Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр хангах
- Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах
- Ажлын байранд хамгаалах хэрэгслээр хангах
- Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж, хэрэгслийг авч байрлуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах
- Байгаль орчны аудит хийлгэх
- Байгууллагын байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, хэрэгжилтийг хянах Дотоод хяналтын нэгж байгуулах

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” болон 2012 оны 05 дугаар сарын 17 өдрийн /Шинэчилсэн найруулга/ “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа “Улаан-Овоо нүүрсний уурхайг ил аргаар ашиглах” үйл ажиллагааны явцад байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан төлөвлөлөө. Үүнд: Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгах шаардлагатай байдаг.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт №4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга Хэмжээний цар, хүрээ	Нэгжийн өртөг (мян. төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт,аргачлал
АГААР						
Уурхайн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, ачилт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болох юм. Мөн хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэх шинж чанартай байна.	Агаарын тоосжилт бууруулах зорилгоор карьерт болон технологийн зам, мөргөцгийг тогтмол услах;	Карьер, үйлдвэрлэлийн зам	1,500.0	1,500.0	Уурхайн олборлолт, ашиглалтын явцад 2026 он	“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль; “Агаарын тухай” хууль; MNS 4585:2016 Агаарын чанар. Ерөнхий шаардлага Монголын агаарын чанарын стандарт MNS3384:82, MNS3383:1982, Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр, нэр томъёо, тодорхойлолт
	Алсын замд нүүрс тээвэрлэх үедээ авто самосвалуудын тэвшийг бүтээж байх шаардлага тавьж ажиллах;	Холын тээвэр	Дотоод хяналтаар		Тээврийн хугацаанд тогтмол	
	Агаар орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх;	ОХШХ-т тусгав.				
	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах	Уурхайн зам	Үйл ажиллагааны зардалд тусгав.		11 сард	
	Хорт хий, дуу чимээ гарч болзошгүй ажлын байранд /тэсэлгээ/ ажиллагсдыг хошуувч, баг, чихний бөглөө зэрэг шаардлагатай хамгаалах хэрэгслээр хангах	Хөдөлмөр хамгааллын зардалд тусгаснаар				
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРС						
Хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах	Овоолгын суурь болон ашиглалтанд шинээр өртөх талбайн үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулах;	Уурхайн хашаан дотор	Үйл ажиллагааны зардалд тусгав		Уурхайн олборлолт, ашиглалтын явцад	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. MNS 5916:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн

Уурхайн эдэлбэр газар болон түүнээс гадна ажилчдын тосгоны болон уурхайн барилга, байгууламжийн орчимд хүний болон машин техникийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгийн өөрчлөлт, доройтолд өртөх магадлалтай	Шимт хөрсийг стандартын дагуу бүтцийг нь алдагдуулахгүй хадгалах, эргүүлэн нөхөн сэргээлтэнд ашиглах;		2,000.0	2,000.0		сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008
Ахуйн болон шатах, тослох материалын хаягдлаар өнгө хөрс бохирдох.	Шатахууны асгаралт үүсэж хөрсөнд нэвчихээс сэргийлж байнгын хяналт тавьж байх	Дотоод хяналтаар				Байгаль орчныг хамгаалах тухай” хууль “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль “Хог хаягдлын тухай” хууль Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850: 2008
	Машин, механизмын засвар үйлчилгээг зөвхөн зориулалтын засварын байр, талбайд хийж гүйцэтгэх; Ажилласан тос, тослох материалын хаягдлыг тос, тослох материалын хаягдал цуглуулах цэгт цуглуулах;					
	Хөрсний чанар, бохирдлыг давтамжтайгаар хянах;	ОХШХ-т тусгав.				
	Тээврийн хэрэгслийн маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулах;	Дотоод төлөвлөлтөөр				
УРГАМАЛ						
Ургамлан нөмрөг устах, доройтох	Уурхай орчмын талбайд ургамлан аймаг, ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжлийн судалгаа, хяналт хийх	Уурхай орчмын талбай	1,000.0	1,000.0	11 сард	БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
УСАН ОРЧИН						
Уурхайн малталтад орж ирэх газрын доорх усыг зайлуулахаас үүдэж газрын доорх усны ашиглалтын нөөц багасаж	Газрын доорх усны нөөц, болон чанарыг хянах зорилгоор Зэлтэр гол болон уурхайн малталтын дунд мониторингийн 3 цооног байгуулах.	Уурхайн бүсэд	Үйл ажиллагааны зардалд тусгав		11 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 6148 - 2010 Газрын доорхи усыг

түвшин буурах					бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Мониторингийн 3 цооногийг газрын доорх усны түвшин хэмжигч автомат Hobo эсвэл Diver багажаар тоноглож мэдээг авч хэмжилтийг тогтмол харьяа усны сав газарт явуулж байх.	Уурхайн бүсэд	Үйл ажиллагааны зардалд тусгав	11 сард	
	Шүүрлийн усан сангийн усанд усны чанарын шинжилгээг улирал тутам тогтмол хийж голын усны чанарт боломжит хэмжээгээр дөхүүлэн нийлүүлэх	Уурхайн бүсэд	ОХШХ-т тусгав.		
Түлш шатахуун, шатах тослох материалууд, бохир ус, химийн янз бүрийн бодисууд асгарч, алдагдсанаас үүдэн бага гүнд орших уст давхарга бохирдох. Усны хэрэглээ ихсэх төслийн талбай, түүний орчмын газрын доорх усны түвшин буурах, голын усны эрчим буурах, гадаргын усны шинж чанар, нөөцөд нөлөөлөх	Өрөмдмөл гүний худгуудын болон ундны усны чанарыг тогтмол давтамжтайгаар хянах	Уурхайн усны хэрэгцээг хангадаг гүний худгууд	ОХШХ-т тусгав.		Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 4586 : 1998 Усны чанар. Хаягдал ус. MNS4943 : 2000 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 900:2018 Усан мандал. Усны чанарын хяналт, шинжилгээ. MNS 4047 : 1988
	Бохир ус цэвэршүүлэх байгууламжийг сайжруулах, хаягдал усыг дахин ашиглах боломжийг ихэсгэж, усны нөөцийг хамгаалах;	Дотоод төлөвлөлтөөр			
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ					
Хүний эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдах	Ажиллагсдыг тусгай хувцас хэрэгслээр[1] бүрэн хангах	Уурхайн бүх ажиллагсад	Аж ахуйн нэгж байгууллагаарсдэлийн төвшнөөс хамааранүйлдвэрлэл, үйлчилгээний ардлын 1.5 хувиас доошгүй эмжээний хөрөнгийг өдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц ордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс рьдчилан сэргийлэх арга эмжээнд зарцуулна.	Ажилтан бүрийг тусгай хувцас эрэгслээр тогтмол хангах.	- Хөдөлмөрийн тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - MNS 4992:2000 - MNS 5029:2011 MNS (ISO) 13688:2000 - MNS 5566-2005 - MNS 6231:2011
	Ажиллагсдыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах			11 сард	
	Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр[2] хангах			Үйл ажиллагааны гуршид	
	Ажлын байранд анхан шатны тусламж үйлчилгээний иж бүрэн багаж, хэрэгслийг авч байрлуулах				
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос		5,000.0	5,000.0	11 сард

[1] “Тусгай хувцас” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хувцас, гутал, малгай,бээлий зэрэг хэрэгслийг хэлнэ.

[2] “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл” гэж үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий хэрэгслийг хэлнэ.

	урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах					
Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн хүрээнд	4,000.0	4,000.0	2 жил тутамд 1 удаа Байгаль орчны аудит хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар 11 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйл.
	Байгууллагын байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, БОМТ-ний хэрэгжилтийг хянах, ХАА-ны дүрэм, стандартыг хянах Дотоод хяналтын нэгж байгуулах	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Дотоод төлөвлөлтөөр		Үйл ажиллагааны туршид	- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл. - Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
Тухайн жилийн дүн					**13,500.0**	

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт №5 Нөхөн сэргээлт

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Нийт, мян.төг
1. Техникийн нөхөн сэргээлтийн ажил				
1	Шимт хөрсний үе давхаргыг хуулах	сая.м^3	0.061	2,500.0
2	Хуулсан шимт хөрсний ачих	сая.м^3	0.061	2,500.0
3	Шимт хөрсний тээвэрлэх	сая.м^3	0.061	2,500.0
4	Овоолгын талбайг хэлбэржүүлэн тэгшлэх, нягтаршуулах	сая.м^3	0.061	2,500.0
В.Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		**мян.төг**	**10,000.0**	
2. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал				
5	Бүрхэвч ургамал тарих	га	-	2,500.0
6	Олон наст ургамлын үр тарьж суулгах	га	-	2,500.0
7	Ойжуулах	га	-	2,500.0
8	Усалгаа, арчилгаа, тордолт хийх	га	-	2,500.0
С.Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		**мян.төг**	**10,000.0**	
Тухайн жилийн дүн		**мян.төг**	**20,000.0**	

4.3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

Сэлэнгэ аймгийн БОУАӨГазраас Түшиг сумын нутаг дэвсгэрт Зэлтэр голын эрэг дагуу 2 га талбайд мод тарих үүрэг өгсөн. Төсөвт зардал 5 сая төгрөг тусгав.

4.4. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Орон нутгийн зүгээс дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд ашиглалтнаас гарсан хуучин хогийн цэгийн 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх үүрэг өгсөн ба тус зардалд 8.08 сая төгрөг тусгав.

4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

“Улаан-Овоогийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд айл өрхийг нүүлгэн шилжүүлэх шаардлагагүй.

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хайгуулын ажлын явцад, уурхайн лицензийн талбайгаас нийт 13 дурсгал ирүүлсэн бүртгэл тэмдэглэж авсны 6 нь зэвсгийн үед (МЭӨ XII-IV зуун), 2 нь дундад зууны үед (МЭ X-XIV зуун) холбогдох булш байгаа бол он цаг тодорхойлох боломжгүй (хэлбэр нь тодорхойгүй) булш 5 байна. Энэхүү хайгуулаар олдсон дурсгалууд бөгөөд эдгээрийг түүх, соёлын өвийг эрэн сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17.10,
17.12 болон “Монгол улсын нутаг дэвсгэр дээр археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дугаар заалтуудыг үндсэн түүх археологийн дурсгалын хадгалалт хамгаалалтад авч анхааран, зайлшгүй тохиолдолд, чөлөөлөх арга хэмжээ авна.

Хүснэгт №6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Түүх соёлын дурсгал	Уурхайн ажлын явцад ямар 1 археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж, авран хамгаалах ажил зохион байгуулах	Тусгай зөвшөөрөл бүхий талбай	Үйл ажиллагааны төлөвлөлтөөр		Уурхайн газар шорооны ажил явагдах үед	- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Хайгуулын ажлын явцад илэрсэн дурсгалууд	Мэргэжлийн байгууллагаар малтлага судалгаа хийлгэх	Тусгай зөвшөөрөл бүхий талбай	5,000.0	5,000.0	Ашиглалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө	- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27.9 - Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам
	Илэрсэн дурсгалыг авран хамгаалах	Олдвор илэрсэн газар	5,000.0	5,000.0	Тухай бүр	
Тухайн жилийн дүн /мян.төг/			**10,000.0**			

4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилансэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээнийцар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын хөрс, барилга байгууламж эвдрэх , уурхай үерийн усанд автах	Үерийн хамгаалалтын суваг, шуудуунд байнга хяналт тавьж засаж янзлаж байх	Уурхайн болон кемп орчин,	Дотоод хяналт, үйл ажиллагааны төлөвлөлтөөр		Тогтмол	Гамшгаас хамгаалах тухай” “Галын аюулгүй байдлын тухай”
Ой хээрийн түймэр гарах, шатах ,тослох материал шатах	Гал унтраах хэрэгсэлээр хангах, ажилчдад гал унтраах сургалт хийж байх Тэсэрч дэлбэрч болох ахуйн хэрэглэлүүд болон тослох материалын хадгалалт, асаралтыг хянаж байх, асгарсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авах Гамшгаас хамгаалах болон галын тухай хууль дүрмийг дагаж ажиллах		1,000.0	1,000.0		
Тухайн жилийн дүн:			**1,000.0**			

4.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт №8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүйсөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээнийцар, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлын ангилан ялгалтыг тогтмол хийх.	Ашиглалтын талбай, кемп, ажлын байруудад	Өдөр тутмын үйл ажиллагаагаар			- Хог хаягдлын тухай хууль - Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага. БОАЖСайдын 2018 оны А/443 дугаар тушаал
2		Хог хаягдлын түр цэг байгуулах		1,000.0	1,000.0	11 сард	
3		Орчны хогонд хяналт тавьж, цэвэрлэгээг тогтмол хийх.		Дотоод хяналтаар			
4	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдлыг эх үүсвэр, төрлөөр нь ангилж кодчилон зэрэглэл тогтоох	“Юү Жи Эл Интерпрайзис” ХХК	2,000.0	2,000.0	11 сард	- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаал - Хог хаягдлын тухай хууль - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/368 дугаар тушаал
5		Хог хаягдлын тооллого хийж, эх үүсвэр тус бүрээс жилд үүсэх хаягдлын төрөл, тоо хэмжээг нарийвчлан тогтоох					
6		Тээврийн хэрэгслийн аккумлятор, ажилласан тос зэрэг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг холбогдох журмын дагуу цуглуулж, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж компаниудтай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх		Гэрээнд заасны дагуу			
7		Ажиллагсдад хог хаягдлын хууль эрхзүйн орчин, хог хаягдлын менежментийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Уурхайн бүх ажиллагсад	1,000.0	1,000.0		
Тухайн жилийн дүн(мян.төг):				**4,000.0**			

4.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн зүгээс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл тэдгээрийн тархалтыг хянах байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг хянах, байгаль орчны бохирдол явагдсан хэсгийг илрүүлэх, сөрөг нөлөөллийг багасгах, нэмэлт арга хэмжээ авах зорилгоор мониторингийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай. Мониторинг нь байгын ажиглалт, шинжилгээгээр гарсан үзүүлэлтүүдийн хяналт тэдгээрийн бие даасан үнэлгээ болон хэтийн төлөв байдлыг урьдчилан таамаглах цогц үйл ажиллагаа юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Юү Жи Эл Интерпрайзес” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутаг дэвсгэрт байрлах “Улаан-Овоо”-ийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа явуулахад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно.

2026 оны үйл ажиллагааг 4-р улиралд явуулах болсонтой холбогдуулан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 4 дүгээр улиралд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тайлант оны үйл ажиллагааны тайлангаар дамжуулан орон нутаг, төрийн захиргааны төв байгууллагуудад тайлагнах болно.

Хүснэгт №9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

БО-ны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Шинжилгээ явуулах төрөл, арга, хэлбэр	Байршил	Баримтлах стандарт	Арга, аргачлал Хэрэглэх тоног төхөөрөмж	Давтамж хугацаа	Нэгжийн зардал (мян.төг)	Тухайн жилийн зардал (мян.төг)
1. Агаарын чанар	Уур амьсгал	Сэлэнгэ аймгийн УЦУОХШ лабораторооос цаг уурын мэдээллийг тогтмол ашиглах						
	Орчны тоосжилт	PM2.5, PM10 Нийт тоосны уналт	Уурхайн дотор болон түүний орчимд тоосжилт хянах 5 цэгт буюу	MNS 4585:2016	Тоосны уналтыг хэмжих багаж, лабораторийн шинжилгээ	11 сард	208.0	208.0
	Агаар дахь хорт хийн шинжилгээ	Азотын давхар исэл (NO_2); Хүхэрлэг хий (SO_2); Тоос, тоосонцор	Уурхайн карьер дотор, Дотоод тээврийн замын орчинд, ННАХ орчим, Засварын газрын орчинд, Кэмпийн орчинд	MNS 4585:2016	Лабораторийн шинжилгээ	11 сард		
2. Хөрсний чанар	Физик болон химийн үзүүлэлт	Элэгдэл, Ялзмаг, pH, $CaCO_3$, Цахилгаан дамжуулах чанар, P_2O_5, K_2O, Механик бүтэц,	Уурхайн орчмын 5 цэгт буюу бусад мониторинг цэгүүдэд	Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага" MNS 3298:1991 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2008	Лабораторийн шинжилгээ	11 сард	1,780.0	1,780.0
	Хөрсний бохирдол	Хүнд металлууд болон нефть, нефтийн бүтээгдэхүүний бохирдол	Уурхайн ашиглалтын талбайн шаардлагатай цэгүүдэд.					
3. Усан орчин	Хими болон Физикийн үзүүлэлт	pH, цахилгаан дамжуулах чадвар, өнгө, атуулаг, хлорид, аммони, нитрит, нитрат, фортофосфат, гидрокарбонат, сульфат, Ca, Mg, Na, K,	Өрөмдмөл гүний худгууд болон усны үйлвэрийн усанд	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 900 : 2018	Усны дээжний сав, Лабораторийн шинжилгээ	11 сард	1,040.0	1,040.0
	Эрүүл ахуйн	Бактерлоги болон микро биологийн	Ашиглагдаж буй бүх усны эх үүсвэрүүд буюу өрөмдмөл худгууд , усны үйлдвэрийн усанд		Усны дээж авах тусгай ариутгасан сав, Лабораторийн шинжилгээ			

4.Урга малан	Хяналт шинжилгээ	Ургамлан аймаг, ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжил	Хяналтын цэгт тогтоох	-	Дижитал зургийн аппарат, туузан метр, хээрийн судалгааны мэдээ цуглуулах маягт	11 сард	500.0	500.0
Тухайн жилийн ОХШХ-ний дүн:					**3,528.0**			

4.10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

Хүснэгт№10 Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Жаргалмандах 1-р баг болон Түшиг сумын ИНХ-д танилцуулах, хэлэлцүүлэх	БОМТ хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлэх, тайлагнах	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлын хэрэгжилт, түүнд санал авах	Сэлэнгэ аймгийн Түшиг сум

Хүснэгт №11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын нэгдсэн дүн

№	БОМТ	Тухайн жилийн БОМТ-ний зардал (мян. төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13,500.0
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4,000.0
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	20,000.0
4	Тэрбум мот үндэсний хөтөлбөр	5,000.0
5	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	10,000.0
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,000.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	3,528.0
8	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	8,080.0
	Бүгд	**65,108.0**

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 32,650,000₮ зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд тухайн оны үйл ажиллагаа 4-р улиралд эхэлж байгаатай холбогдуулан нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа болон “тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэхээр БОНҮҮ-нд тусгагдсан ажлуудыг төлөвлөөгүй болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасан үүргээ хангахаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 50%-ийг байршуулсан болно.

ДҮГНЭЛТ

“Юү Жи Эл Интерпрайзес” ХХК нь өөрийн эзэмшлийн MV-022059 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Улаан-Овоо” нүүрсний уурхайгаас 2026 онд нийт олборлох нүүрсний хэмжээ 512.0 мян.тн, хөрс хуулалт 612.0 мян.м^3 ажил гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Манай компани 2026 оны 06 сарын 27-ны өдөр “Гоби кокинг коал” ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд дээрх уулын ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр нийт 65,108,000₮ төлөвлөсөн.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасан үүргээ хангахаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 50%-ийг гэрээгээр ажил гүйцэтгэх “Гоби кокинг коал” ХХК-ийн нэрээр байршуулсан болно.

Дэлхий дахинд үүсээд буй дайн байлдааны нөхцөл байдал, уул уурхайн гол хэрэглэгдэхүүн болох дизель түлшний хомсдол зэрэг цаашид тогтвортай байж манай уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа нөхцөлд БОНҺҮ-нд тусгагдсан байгаль хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэн орон нутаг, төрийн захиргааны байгууллагуудад тайлагнан ажиллах болно.